



МОНГОЛ ДАХЬ ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨН ТҮҮНИЙ НЭЭЛТ БА ХААЛТ

Илтгэгч: **Р. Онон, оюутан**

MPhil in Sociology, University of Cambridge, UK

Удиртгал

2008 оны 6 сард болсон парламентын сонгуулын үр дүнг эсэргүүцэн 7 сарын 1-нд иргэд болон сонгуульд ялагдсан нэр дэвшигчид эсэргүүцлийн жагсаал цуглааныг аймаг, хот хөдөө, дүүрэгт зохион байгуулав. Энэхүү жагсаал цуглааны гол зорилт нь сонгууль булхайтай явагдсаныг олон баримтаар нотлон, дахин сонгууль явуулах шаардлага тавьж байв. Жагсаал цуглаан аажимдаа өргөсөн олон нийтийг хамарч нийгмийн эмх замбараагүй байдлыг үүсгэн, зохион байгуулсан удирдагч нар эргэн зохицуулж чадахгүй болсноор гал тавих, эвдэн сүйтгэх, чулуу нүүлгэх зэрэг үйлдэл газар авчээ. Монгол Улсын Ерөнхийлөгч Намбарын Энхбаяр шөнийн 23:30 онц байдлыг орон даяар 4 өдөр тогтоож, үндэсний олон нийтийн радио телевизээс бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийг хаалаа. Үр дүнд МАХН-ын төв байр, соёлын төв өргөөний хэсэг, хэд хэдэн машин шатаж, 5 хүний амь эрсдэж, 1000 гаруй хүн баривчлагдаж, мэдээллийн хэрэгслүүд хаагдаж, их хэмжээний эвдрэл, хохирол учирсан байна.

Ач холбогдол

Дээрх болсон явдлыг нарийн нягталж үзвэл сүүлийн 3-4 жилд гарсан Монголын нийгэм-эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал хүмүүсийн амьдралд хэрхэн нөлөөлснийг судласнаар зарим нэг мэргэжлийн тайлбарт хүрэх болов уу. Энэ нь сүүлийн үед олноор үүсэх болсон нийгмийн хөдөлгөөн, эсэргүүцлийн жагсаал цуглааныг давхар түүхэн цаг үетэй нь давхцуулан судлахад сонирхолтой уялдаа холбоо, үзэгдэл гарч ирж байна.

Сүүлийн үед олноор үүссэн нийгмийн хөдөлгөөний талаар судалсан судалгаа, ном товхимол бараг байхгүй гэж болох ба ганц судлаач Д.Болдын бичсэн Мөргөлдөөний тухай гэдэг номноос өөр бариад авчих юм алга. Гэхдээ 7 сарын 1-ний үйл явдалтай холбоотой гадаад дотоодын сонин, хэвлэл сэтгүүл дээрх өгүүлэг, нийтлэгүүдийг нэрэлбэл бас нэлээдгүй юм байна. Жишээ нь: Кембрижийн их сургуулийн багш нарын бичсэн Өвөр Азийн сэтгүүл дээр гарсан өгүүлэг, судлаач Ч.Тамир болон Наранжаргалын нийтлэл өгүүлэгүүд, Нээлттэй Нийгэм Форумгаас санхүүжүүлсэн онц байдалтай холбоотой хүний эрхийн зөрчлийн мониторинг, хамгааллын эвсэлийн тайлан, интернет вэб хуудсаар нээлттэй хэлэлцүүлэг, Оросын хэвлэл мэдээлэл болон тэдний судлаачдын байр суурь, цахим сонин зэрэг олныг дурьдаж болно.

Үүнээс гадна олон улсын олон судлаачид онолын хүрээнд нийгмийн хөдөлгөөнөөр бичсэн ном, эрдэм шинжилгээний сэтгүүлд гарсан өгүүлэгүүдээс харахад Чарльз Тилли, Сидней Тарроу, Марк Бейссэнжир, Скотт Раднитз, Жошуа Голдстэйн, Хэрбэрт Блумэр, Макарфи, Залд нарын бичсэн зүйлс сонирхол их татлаа. Жишээ нь: Тилли, Тарроу нар нийгмийн хөдөлгөөнийг улс төрийн дэглэм, зөрчлийн улс төр болоод ардчилалтай холбож үзсэн байхад, Бейссэнжир үндэсний онцлог шинж болоод пост-коммунист орнуудад тулгарч байгаа нийтлэг үзэгдэл буюу энэ нь бие биендээ загвар болж өгдөг гэсэн бол Раднитз болон Голдстэйн нарын шинэ техник технологи нийгмийн хөдөлгөөнд ямар үүрэг гүйцэтгэж байгааг харуулсан. Сэтгэл судлалын үүднээс ч олон нийтийн эвлэлдэн нэгдэх нь түр хугацааны зохион байгуулагдсан институци гээд хэрхэн сэдэл өгдөгийг үхэр дээр аналогоор буюу нэг үхэр мөөрөхөд бусад нь мөөрдөг, нэг үхэр ямар нэг юмнаас үргэн зугатахад бусад нь дагадаг тухай тайлбарласан. Эцэст нь Макарфи, Залд нарын дэвшүүлсэн нөөц хүчийг ашиглан нийтээр нэгдэх онол нь миний судалгаанд ихээхэн ач тус өгсөн.

Иймд энэхүү сэдвийг судлах нь цаг хугацаа болоод сэдэв салбарын хүрээнд багахан ч гэсэн хувь нэмэр оруулах юм болов уу. Ялангуяа өндөр хөгжилтэй улс орнуудын хувьд нийгмийн хөдөлгөөнийг судлахдаа асар өргөн, олон талын өнцгөөс нийгэм, улстөрд гарсан өөрчлөлт, түүнийг бүрэлдүүлж байгаа орчинг давхар судлах зэрэг янз бүрийн аргатай. Тэдний судалгаанаас санаа оноо авах, өөрийн өвөрмөц онцлогийг илтгэхэд онол практикийн их ач холболдолтой.

Судлах арга зүй

Судлах арга зүй 2 үе шаттай.

1. Түүхчлэн 2005 оноос хойшхи нийгэм-эдийн засаг, улс төрийн асуудлыг авч үзэх
2. Чанарын арга зүйгээр төлөөлөл бүхий хүнээс нээлттэй ярилцлага авах

Дээрх арга зүйг тус тусд нь товчхон авч үзье.

Эхний арга зүй нь цэвэр статистик мэдээ, мэдээлэл дээр тулгуурлах ба үндэсний статистикийн газрын мэдээлэл, дотоод гадаадын олон улсын ашгийн бус байгууллагын тайлан, мэдээ, мэдээлэл дээр түшиглэнэ.


Дараагийн судлах арга зүйгээ ерөнхийд нь чанарын арга зүйгээр хийж байгаа боловч зарим нэг судалгааны явцад шинээр гарч ирж буй мэдээлэл нь тоон арга зүйн ерөнхий түвшинд хамтатган хийх байдал гарч байна.

Чанарын арга зүйгээр нийт 15 орчим хүнээс нээлттэй ярилцлага авч тэрийгээ боловсруулалт буюу кодоод оруулна. 15 хүнээ 3 бүлэгт хуваан нийгмийн төлөөллийг тухайн сэдэвтэй уялдуулан сонгох ба санамсаргүй түүврийн аргаар сонгон авна.

Эдийн засгийн байдал

Монголд сүүлийн жилүүдэд үүссэн нийгмийн хөдөлгөөнүүдийг ард түмний амжиргааны төвшин доройтсонтой авч үзвэл ДНБ өсөлт, ажилгүйдэл, инфляци буюу үнийн өсөлт зэргийг авч үзэх хэрэгтэй. Одоо тус бүрд нь авч үзвэл дараах байдлууд харагдаж байна.


2000 оноос хойшхи эдийн засгийн үндсэн үзүүлэлт ДНБ-ийг харвал муу биш байгаа нь дорхи графикаас харагдаж байна.



2004 оны байдлаар 10-аас дээш хувь өссөн бол 2005 оны байдлаар бараг 7 хувьтай. 2007 оны байдлаар 10 хувьд эргэн хүрч 2008 оны сүүлчээр 8-аас дээш хувийн өсөлтүүд харагдаж байна. Хэдийн энд жини коэффициент үзүүлээгүй ч ерөнхий дүр зургаар муугүй. Гэхдээ ДНБ илт өслөө гээд хүмүүсийн амьжиргааны төвшин нэмэгдэхгүй. Энэ нь тухайн үеийн засгийн газрын бодлого, хуваарилалтаас шууд хамаарна. Өөрөөр хэлбэл, хуваарилалт шууд амьжиргааны төвшинд нөлөөлдөг байхад ДНБ нөлөө үзүүлэх бололцоогүй юм. Цөөн бүлгийн эрх ашигт нийцэх, улс орны сан хөмрөгийг дээшүүлэхээс илүү гарах нь бага. Гэсэн хэдий ч тухайн орны хөгжил дэвшлийг ДНБ-нээр хэмждэг тогтоцтой. Дараагийн графикайг харна уу. Тэгвэл ДНБ-ийн өсөлт 2008 оны улирлаар ямар байсан бэ?




Эхний хагаст 15 хувиас илүү өссөн бол 2, 3-р хагаст 8-аас дээш хувьтай, бараг 4 хувьтай байсан байна. Хэдий сүүлийн 2 хагаст огцом буурсан боловч энэ нь дэлхийн эдийн засгийн хямралтай шууд холбоотой. Тэгвэл дараагийн нэг шалгуур болох ажилгүйдлийг 2000-2008 оны байдлаар авч үзвэл:



Ерөнхийдөө муугүй үзүүлэлт харагдаж байна. Нийтдээ 2000 оноос хойшхи ажилгүйдлийн үзүүлэлт 40000 хүн буюу нийт хүн амын 4 гаран хувь авч байгаа бол 2008 оныхоор бол 30000 хүн ажилгүй гэж бүртгэгдсэн нийт хүн амын 3 хувиас илүүгүй байна. Дараах графикаар ажилгүйдэл аль саруудад эрчимтэй өсч байгааг харж болно. Эндээс харах юм бол ажилгүйдэл зуны саруудад буюу 5 сараас 7 сарын эхэн хүртэл эрчимтэй өсч байна. Энэ нь 2006, 2007, 2008 онуудад үзүүлэлтүүд бараг өөрчлөлтгүй харьцангуй адил байна. Эндээс дүгнэхэд сүүлийн жилүүдийн ажилгүйдлийн байдал харьцангуй тогтвортой байсан ба ажилгүйдэл ихэвчлэн зуны улиралд ихэсдэг нь эндээс харагдаж байна. Тэгвэл Монголд иргэний хөдөлгөөнүүд үүсэх болсон шалтгаанд ажилгүйдэл холбоотой юу? Холбоотой бол ямар хэлбэрээр, ард иргэдийн нийгмийн асуудлын бухимдал уу эсвэл ажилгүй хэдэн хүний хэд нь хөдөлмөрийн биржид бүртгүүлдэг вэ? 7 сарын 1-

нд гарсан бослого үймээнд оролцсон хүмүүсийн нийгмийн анкет энд ямар тайлбар өгөх бол гэхчилэн асуултууд цувах болно.



Үнийн өсөлт

Дараах бас нэг хүчин зүйл нь тухайн үед гарч байсан инфляци болон үнийн өсөлт юм. Суурь үнийн өсөлт 2006-2008 оны хооронд эрчимтэй өссөн. Энэ нь олон нийтийн бухимдал, дургүйцэл бий болж, олон нийт зохион байгуулалтанд орох нөхцөл бүрдүүлсэн болов уу. Ялангуяа үнийн өсөлт 2008 онд 4 дахин өсөж 2006 оны байдалтай харьцуулахад 21 хувиас дээш өссөн байна.

Энэ үеийн үнийн өсөлтөнд гол нэрийн бүтээгдэхүүн буюу хүнсний бүтээгдэхүүний үнэ 2008 оны 5 сарын байдлаар 38.9%-иар 2007 оны 5 сараас өссөн ба аажимдаа 2008 оны сүүлээр буурсан. Үнийн өсөлт нь олон нийтийн амжиргааны төвшинд шууд нөлөөлсөн буюу бухимдал дургүйцлийг төрүүлж зарим нэг нийгмийн нэн ядуу, эмзэг бүлэг хэсгүүд олон нийтээрээ эвлэлдэн нэгдэж эсэргүүцлийг өрнүүлсэн байх илүү магадлалтай. Түүнээс биш ДНБ-ний өсөлт, ажилгүйдэл нь ард иргэдийн амьдралд шууд нөлөө үзүүлэх тохиолдол харьцангуй ховор.

Эндээс эдийн засгийг ерөнхийд дүгнэхэд ДНБ-ний өсөлт, ажилгүйдлийн статистик харьцангуй сайн боловч хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт огцом өссөн нь олон нийтийн буюу ялангуяа өрхийн орлого багатай хүмүүсийн бухимдлыг төрүүлсэн байх магадлал өндөртэй. Үүний үр дүнд олон нийтийн хөдөлгөөн, цуглаан идэвхижин нийгэмд өөрсдийн дуу хоолойгоо гаргасан гэж үзэх үндэслэлтэй.

Үүгээр эдийн засгийн нөхцөл байдлыг орхиод нийгэм, улс төрийн байдлыг тандан үзье.

Нийгэм, улс төрийн харилцаа

Монгол Улс чөлөөт либерал ардчилсан орны Freedom House-ын жагсаалтанд 1998 оноос хойш “чөлөөт” ардчилалтай ангилалд багтаж байгаа. Тэгвэл нийгмийг тандан судалдаг тэдний нэг шалгуур бол жилд хичнээн төрийн бус байгууллага (ТББ) байгуулагдаж байна гэдгийг онцгойлон анхаардаг. Тиймээс өнөөдөр төрийн бус байгууллагын хууль батлагдснаас хойш 7000 гаруй ТББ байгуулагджээ. Дорхи хүснэгт бол зөвхөн 2000 оноос хойш 2007 он гэхэд л 5000 гаруй ТББ байгууллага байгуулагдсан байна.

	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007
ТББ	460	446	481	637	988	574	593	897

Энэ нь нийгэм хир их ардчилсан бөгөөд олон ургальч үзлийг хөхүүлэн дэмждэгийг харуулж байна. Зарим нэг иргэний хөдөлгөөнүүд нэгдэн нягтарч ТББ болон бүртгүүлсэн бас нэлээдгүй олон тооных байх. Жишээлбэл: Эрүүл нийгэм иргэний хөдөлгөөн, даяар монгол, газар шороо гэх мэт.

Үүнтэй зэрэгцээд 2005-2006 оны хооронд үүссэн зөвхөн хөдөлгөөнүүдийг дор жагсаалаа. Зөвхөн гэдгийн учир нь цаана хөдөлгөөнөөс өөр түр хороо, бүлгэм, холбоо гэх мэт шинэ олон нийтийн сайн дурын эвслүүд олноор үүссэн.

Орон нутгийн хөдөлгөөн

- Онги гол хөдөлгөөн
- Онон Улз голынхон хөдөлгөөн
- Уугуул хөдөлгөөн
- Хөвсгөл далай хөдөлгөөн
- Ариун суврага хөдөлгөөн
- Хонгор нутгийн дуудлага
- Тосон заамар туул хөдөлгөөн
- Ардын элч хөдөлгөөн
- Эх дэлхий хөдөлгөөн
- Миний монголын газар шороо хөдөлгөөн
- Оюу толгой 50/50 хөдөлгөөн

Иргэний хөдөлгөөн

- Даяар монгол хөдөлгөөн
- Эрүүл нийгэм иргэний хөдөлгөөн
- Хөжлийн телсэх иргэний хөдөлгөөн
- Эрс шинэчлэл хөдөлгөөн
- Ард түмний түр хороо
- Сонгогчдын эрх ашгийг хамгаалах хөдөлгөөн

- Шинэ давалгаа хөдөлгөсөн
- Улаан зүрхтэн хөдөлгөсөн
- Бодлогын судлаачдын клуб
- Хөх цуст монголчууд
- Иргэний Форум

Дээрх иргэний хөдөлгөөнүүд дангаар буюу эвсэн 2005 оны байдлаар 30-аад жагсаал цуглаан хийсэн бол 2006, 2007 онуудын байдлаар нийтдээ 10 гаран жагсаал, цуглаан эсэргүүцэл өрнүүлжээ. Жагсаал цуглаан хийдэг давтамжыг 2005 оноор аваад үзвэл ихэнхи нь 3, 4 сард хийгдсэн буюу эргэн 10, 11 сараас идэвхиждэг уур амьсгал харагдаж байна. Гэтэл 6, 7 сард нэг ч жагсаал цуглаан хийгээгүй байна. Энэ давтамж нь ерөнхийдөө 2006, 2007 онуудтай адил. Үүнээс дүгнэхэд 7 сарын 1 үүсэх болсон гол асуудал нь сонгуульд байх бүрэн үндэстэй болохоор улс төрийн байдлыг сонирхвоос.

Улс төр

Улс төрийн хүрээнд авч үзвэл 2000 оны сонгуулиар МАХН үнэмлэхүй олонхийн санал авч парламентад 76 суудлаас 72-ыг авсан бол, 2004 оны сонгуулиар 37 суудал авч сөрөг хүчинд ихэнхи суудлаа алдснаар эвсэл 35 суудал авсан бол 2008 оны сонгуулиар эргэн олонхи болж 45 суудал авчээ. Энэ хэлбэлзэл их сонирхолтой боловч бидэнд хамгийн их сонирхол татах үе бол 2005-2008 онуудын хоорондох үе.

Өмнөх МАХН ганцаар төр барьж байсан 2000-2004 оны хооронд сэтгүүлчид, чөлөөт уран бүтээлчдийн эрх зөрчигдөж хамгийн их сэтгүүлчид шүүхэд дуудагдсан үе болсон бол 2004 оны сүүлч буюу 2005 оны эхээр олон ургальч үзэл эргэн бэхжиж хамгийн их хөдөлгөөн, үймээнтэй жилүүд болсон байна. Тэгвэл 2005-2008 оны хооронд хоёр том нам бараг эн тэнцүү суудалтай болсноор олон ургальч үзлийн хөрс бүрэлдсэн үү? Эсвэл 2000-2004 оны хооронд МАХН эрх барихдаа нийгмийн бухимдлыг дэврээсэн үү? Гэдэг асуултууд юун түрүүнд тавигдана.

Иймд адармаатай бөгөөд дуулиан, маргаантай байдалд хүргэдэг сонгуулийн системийг аваад үзвэл систем угаасаа хувь илүү авсан нам шууд ялалт байгуулдаг энгийн мажоритор системээр явагддаг. Хэдий цөөнхийн санал нийтдээ олонхоос илүү ч олон нэр дэвшигчид хуваагдсанаар үр дүнгүй болдог. Эндээс харахад нийгмийн хөдөлгөөнүүдийн үүсэх болсон шалтгаан эдийн засагтай холбоотой юу эсвэл Монголын нийгэм өөрөө улс төржсөн нийгэм учраас улс төрийн хүчнүүдийн хоорондын тэмцлээс залхсан, ядарсан нийгмийн доод давхарааны хүмүүсийн нэгдэл байсан үү?

Дүгнэлт

Дээрх чадан ядан тайлбарлах гэж мэрийсэн санаанууд болбоос:

Нэгт, эдийн засгийн хүчин зүйлс нийгмийн хөдөлгөөн үүсэхэд нөлөөлсөн гэвэл ДНБ, ажилгүйдлийг ажиглахад таагүй нөхцөл байдал харагдахгүй боловч хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт амжиргааны төвшинд шууд нөлөөлөх бүрэн боломжтой тул үнийн өсөлт нийгмийн хөдөлгөөн үүсэх нэг шалтгаан болсон.

Хоёрт, нийгэм нь өөрөө олон ургальч либерал тогтолцоотой үүндээ ч жил болгон байгуулагдаж байгаа ТББ-ын тоо бусад пост-коммунист орнуудтай харьцуулахад харьцангуй их байгаа нь дэмжлэг авах үндэстэй.

Гуравт, мөн л Монголын нийгэм хүн ам, нутаг байршил, соёл зан заншлаасаа ч аваад үзсэн мөн л улс төржсөн нийгэм. 4 жилийн Парламентын үе шатлал тухайн жилүүдийн хөгжлийг тодорхойлдог гэж үндсэндээ хэлж болно. Тиймээс 2005-2008 оны хоорондох жилүүдэд олон нийтийн үг хэлэх эрх, эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх, мэдээлэл авах эрх, эрх чөлөө харьцангуй нээлттэй болсон байх гэж үзэж байна.

Дөрөвт, 7 сарын 1-нд ард олон үй олноороо цугласан нь яг ажилгүйдэл нэмэгддэг үе байсантай таарч (дээрхи ажилгүйдлийн график) байгаа нь харагдаж байна. Тиймээс үнэ цэнийн хувьд сонгуулийн нөлөөгөөр нийгэм хаашаа ч хольбирч болохыг түүхэн энэ туршлагаас харлаа.

Мөн судалгаа нь цаашид үргэлжлэн явагдах бөгөөд одоогоор хөндөж байгаа зарим асуулдууд цаашид дэлгэрэнгүй боловсруулалтанд орох магадлалтай. Иймд дээрх хэлэлцүүлэгийг нээлттэй үлдээлээ.

Ном зүй

1. Badamragchaa, P. et al. 2009. Onts Baidaltai Holbootoi Hunii Erhiin Zurichiin Monitoring, Hamgaallyn Evsel: Barimtjuuultyn Tailan. Open Society Forum: Ulaanbaatar.
2. Bailey, D. Kenneth 1987. *Methods of social research* (3rd ed) The Free Press, New York and London
3. Beissinger, Mark R 2007. "Structure and Example in Modular Political Phenomena: The Diffusion of Bulldozer/Rose/Orange/Tulip Revolutions". *Perspectives on Politics*, Volume 5, No 2.
4. Delaplace, Gregory, Christopher Kaplonski and David Sneath 2008. "The end of post-socialism? An account of the 1st of July riots in Ulaanbaatar, Mongolia", *Inner Asia*, Vol 10 (November), pp. 323-365.
5. Goodwin, Jeff and Jasper, James M. 2007. *Social Movements: critical concepts in sociology*. Routledge. Vol.1 Taylor and Francis Group. London and New York
6. Klandermans, Bert and Suzanne Staggenborg 2002. *Methods of Social Movement Research*. University of Minnesota Press. Minneapolis.
7. Maxwell, Joseph Alex. 2005. *Qualitative Research Design*. Sage. Thousand Oaks, CA.

8. "Mongolian State of Emergency," BBC, July 1, 2008, <http://news.bbc.co.uk/1/hi/world/asia-pacific/7484580.stm>, accessed: January 25, 2009.
9. <http://data.un.org/> accessed: April 10, 2009
10. <http://www.nso.mn> accessed: April 12, 2009
11. <http://www.mongolnews.mn> accessed: December 3, 2008
12. <http://www.oloo.mn> accessed: between January and February, 2009
13. <http://www.freedomhouse.org> accessed: March 4, 2009
14. Radnitz, Scott 2006. "What Really Happened in Kyrgyzstan?," *Journal of Democracy*, Volume 17, No. 2.
15. Ravdan, Bold 2008, *Murgulduunii tuhai*, Admon Press, Ulaanbaatar
16. Tarrow, Sidney 2004. "Bridging the Quantitative-Qualitative Divide," in Brady, Henry & David Collier, *Rethinking Social Inquiry*. Rowman & Littlefield. Lanham, MD.
17. Ragin, C. Charles. 1994. *Constructing Social Research*. Pine Forge Press. Thousands Oaks and London and New Delhi
- Tilly, Charles. 2004. *Social Movement*. The Paradigm Publishers LLC. Boulder